



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 08 өдөр

Дугаар 1/158

Хархорин сум

Хөдөө аж хөдөө аж ахуйн салбарын
2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.1.1, Засгийн газрын 2024 оны 08 дугаар 07-ны өдрийн “Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 28 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах тухай” А/635 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөө аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах, шалган хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Лхагвасүрэн (Засаг даргын орлогч)

Гишүүд :

Э.Нарангарав (Мал эмнэлгийн тасгийн дарга)

С.Мөнхсоёл (Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Ц.Үүрийнтуяа (Нэгдсэн эмнэлгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Д.Оюун-Эрдэнэ (Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга)

Ц.Түмэнбаясгалан (Хархорин ус цаг уурын салбарын эрхлэгч)

Г.Ууганбаяр (Хархорин АЗЗА ТӨХК-ны ерөнхий инженер)

Н.Намхайнямбуу (Онцгой байдлын хэлтэсийн дарга, Дэд хурандаа)

Багийн Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга: Э.Үүрцайх (Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн)

2.Өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангах арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтэнд нь байнгын хяналт тавьж холбогдох арга хэмжээг тухай бүрт нь авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Лхагвасүрэн)-д үүрэг болгосугай.

3.Өвөлжилтийн бэлтгэл ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж явц, үр дүнг 2024 оны 10 дугаар сарын 15-ны дотор Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсэг (Б.Лхагвасүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ОДГЭРЭЛ